

УИД ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

УИД ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, 7-р хороолол, Барилгын дэвшилтэт технологийн төвийн 6-р давхарт 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цаг 20 минутад эхлэв.

Хурлыг УИД ХК-ийн Гүйцэтгэх захирал Санжаагийн Сайнбат даргалав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Гүйцэтгэх захирал Сайнбат нээв.

С.Сайнбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг С.Сайнбат гэдэг. УИД ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолд тооллогын комиссыг хуралд оролцогчдоос томилохоор шийдвэрлэсэн байгаа. Иймд та бүхнээс хурлын тооллогын комисст орох хүн байна уу. Хэсэг хүлээ. Миний зүгээс тооллогын комиссын даргаар тооцооны нягтлан бодогч, С.Лхагважавыг томилох саналтай байна. Учир нь өмнө нь тооллогын комисст ажиллаж байсан туршлагатай хүн байгаа. Өөр тооллогын комисст орох хүн байна уу?

С.Дэлгээн: Намайг С.Дэлгээн гэдэг. Хувьцаа эзэмшигч "Би Ди Сек" ХХК-ийг төлөөлж оролцож байгаа. Тооллогын комисст орох саналтай байна.

Б.Жүгдэррагчаа: Намайг Б.Жүгдэррагчаа гэдэг. Тооллогын комисст ороход татгалзах зүйлгүй.

С.Сайнбат: За хурлын тооллогын комиссын даргаар "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн тооцооны нягтлан бодогч С.Лхагважавыг, гишүүдээр хувьцаа эзэмшигч Б.Жүгдэррагчаа, хувьцаа эзэмшигч Би Ди Сек ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Дэлгээн нарыг томилох уу? Дэмжиж байна уу?

Хуралд оролцож байгаа гишүүд бүгд гараа өргөж дэмжив.

С.Сайнбат: Хурлын ирцийг хурал зохион байгуулах комиссоос гаргасан байна. Энэ ирцийг тооллогын комисс бүртгэлтэй тулгаж хянаад тогтоолоо гарган баталгаажуулна. Цаг хэмнэх үүднээс хурал зохион байгуулах комиссын гаргасан хурлын ирцийг танилцуулах уу? Та бүхэн дэмжиж байна уу?

Хуралд оролцогчид бүгд гараа өргөж дэмжив.

С.Сайнбат: Өнөөдрийн хуралд нийт 22,251,092 ширхэг саналын эрхтэй хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн буюу хурлын ирц 60,45 хувьтай байна. Компанийн тухай хуульд зааснаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ирц бүрдсэн тул хурлыг хүчинтэйд тооцож эхлүүлэе.

С.Сайнбат: Та бүхэнд хурлын дэгийн дагуу гүйцэтгэх захирал миний бие компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулъя. Улсын их дэлгүүр нь 1924 онд анх Зөвлөлт Холбоот Улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар суурь нь тавигдан "Төв дэлгүүр" нэртэйгээр ашиглалтанд орсноор үүсэн байгуулагдсан. "Төв дэлгүүр" нь дарга, сургагч, ахлах нягтлан бодогч, даноны сургагч, тооцооны нягтлан бодогч, даноны дагалдан, барааны сурган боловсруулах мэргэжилтэн зэрэг 10-аад ажилтантай байсан.

1933 онд "Төв дэлгүүр" нь шинэ байранд орсноор одоогийн уран зургийн галлерей нь Их дэлгүүр гэж нэрлэгдэх болсон байна. Улмаар 1959 онд Засгийн газрын хуралдаанаар ардын хувьсгалын 40 жилийн ойд зориулж их дэлгүүрийг барих нь зүйтэй гэж шийдвэрлэсний үндсэн дээр дэлгүүрийн барилгын ажлыг эхлүүлж 1961 оны 6 сарын 28-ны өдөр Улсын Их Дэлгүүрийн одоогийн байрыг ашиглалтанд оруулсан байна. Ийнхүү ашиглалтанд оруулснаас хойш олон жил болж байгаа байнгын засвар үйлчилгээ хийх шаардлагатай, анх хийгдсэн шийдлүүд, тоног төхөөрөмжүүд нь хуучирсан, хогцогдсон, засаж сэлбэхэд хүндрэлтэй зардал өндөртэй байдаг. 2018 онд Улсын их дэлгүүрийн барилгад дараах засваруудыг хийсэн үүнд: В1 давхарын ачааны лифтний болон гадна хананы хөрсний ус тусгаарлагч хийх ажил, 1-5 дугаар давхаруудын цонхны шил шинэчлэн шиллэх ажил, 1,5 давхарын дулаалгын ажил, барилгын галын шугамын дохиоллын засвар шинэчлэлт, В1-2 дугаар давхаруудын цахилгааны ерөнхий самбаруудын засвар шинэчлэлт, 3-р давхарын дүүжин тээврийн засвар, 3,4,5-р давхаруудын агаарын урсгалын хаалт хийх ажил, 4,5,6-р давхаруудын шалны хулдаас плита сольж засах ажил, 6-р давхарын нэмэлт гэрэлтүүлгийн ажил, 7-р давхарын өндрийн хэрэгслэл, бөхөлгээний засвар шинэчлэлтийн болон бусад засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн та бүхэн мэдэж байгаа, УИД-ийн 2 ширхэг лифт бол олон жил ашиглагдсан, багтаамж багатай, удаан, агааржуулалтын систем муутай лифт байсан. Үүнийг Бүгд найрамдах Беларусь улсад үйлдвэрлэсэн хүн зөөврийн DP60 маркын 1000 кг даалтай, 1.75м/с хурдтай, 1450*1650 хэмжээтэй бүхээгтэй лифтээр сольсон.

Өмнө дурдсанчлан Улсын Их Дэлгүүрийн барилга нь 1961 онд ашиглалтанд орсон, үүнээс хойш 60-аад жил болж байгаа, их хуучирсан тул жил ирэх тугам засвар үйлчилгээ хийлгэх нь ихсэж, зардал нэмэгдэж байна. Тухайлбал, бид дараахь ажлуудыг энэ жил хийх шаардлагатай байгаа. Эдгээр ажлуудыг хийх зээхийг ТУЗ-ийн хуралд оруулалцуулж шийдвэрлүүлсэний үндсэн дээр эдгээр засварын ажлуудыг хийх болно. Үүнд:

Хөргөлтийн системийн гадна аппарат шинэчлэх 41 сая төгрөг
Хөргөлтийн систем-Чиллерийн засвар үйлчилгээ 36 сая төгрөг
1.5 давхарын агааржуулалтын системийн шийдэл 35 сая төгрөг
Хөргөлтийн системийн гадна агрегат шинэчлэх 41 сая төгрөг
Бүх 00 ерөөнд засвар хийж шинэчлэх 60 сая төгрөг
Нөөцийн усны бак солих 32 сая төгрөг
Давхаруудын дотор заслын ажил 42 сая төгрөг
5 давхарын хананы засвар 12 сая төгрөг
Дулааны үзэлийн дотор хана, шалны засвар 13 сая төгрөг
Дорооны усны хаялга, дээврийн засвар 23 сая төгрөг
Агааржуулалтын системийн засвар шинэчлэлт 500 сая төгрөг.
Төв болон зүүн баруун гол хаалгануудыг мэдрэгчтэй эргэдэг хаалгаар солих /Герман хаалга 1 бүр 200 сая төгрөг/

Санхүүгийн үйл ажиллагааны талаар: Тус компани өнгөрсөн онд нийтдээ 5,394.4 сая төгрөгийн орлого олсон байна. Тайлант хугацаанд орлогын татварт 44.1 сая төгрөг төлж, үндсэн үйл ажиллагаанаас 421.1 сая төгрөгийн ашигтай ажилласан. Харин харамсалтай нь ханшийн зөрүүний алдагдал 444.7 сая төгрөг болсон байна.

Тайлант хугацаанд 4,973.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 39.8 сая төгрөгөөр буурсан байна.

Үйл ажиллагааны зардлыг бүтцээр нь ангилж үзвэл 1.3 хувь буюу 65.4 сая төгрөгийг боловсон хүчний болон хөдөлмөрийн зардал, 44.4 хувь буюу 2,209.1 сая төгрөгийг ашиглалтын зардал, 3.4 хувь буюу 166.9 сая төгрөгийг барилгын урсгал засварын зардал, 11.3 хувь буюу 560.2 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 32.9 хувь буюу 1,636.6 сая төгрөгийг зээлийн хүүгийн зардал, 2.6 хувь буюу 128.7 сая төгрөгийг үл хөдлөх хөрөнгийн болон газрын татвар, 4.1 хувь буюу 206.4 сая төгрөгийг бусад зардал эзэлж байна.

Өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн дүн 8,597.3 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 1.3 хувь буюу 114.6 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 98.7 хувь буюу 8,482.7 сая төгрөгийг эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн 10.6 хувь буюу 12.1 сая төгрөгийг мөнгө, авлага зэрэг түргэн хөрвөх хөрөнгө, 17.4 хувь буюу 20.0 сая төгрөгийг бараа материал, 72.0 хувь буюу 82.5 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хувь болох 99.6 хувь буюу 14,171.6 (хуримтлагдсан элэгдэл нь 5,722.7 сая төгрөг) сая төгрөгийг үндсэн хөрөнгө болох барилга байгууламж, машин тоног техээрэмж, тавилга, эд хогшил, 0.4 хувь буюу 33.8 сая төгрөгийг урт хугацаат хөрөнгө оруулалт эзэлж байна. Урьдчилж төлсөн зардлын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 170.0 сая төгрөгөөр буурсан нь Улсын их дэлгүүрийн зорчигч тээврийн 2ш цахилгаан шатыг бүрэн угсарч ашиглалтанд оруулсантай холбоотой байна.

Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн хувьд бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 9,832.9 сая төгрөг, эзэмшигчдийн өмчийн дүн -1,235.6 сая төгрөг байна. Бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ өнгөрсөн оны эцэст 10,149.4 сая төгрөг байснаас 3.1 хувиар буюу 316.5 сая төгрөгөөр буурч, 9,832.9 сая төгрөг болсон байна. Нийт өр төлбөрийн 97.3 хувь буюу 9,567.0 сая төгрөгийг зээл, зээлийн хүүгийн хуримтлагдсан өр эзэлдэг бөгөөд өмнөх оны эзэлийн үлдэгдлээс 3.5 хувиар буурсан байна. Эзэмшигчдийн өмч оны эхэнд -1,167.8 сая төгрөг байснаас тухайн тайлант хугацааны алдагдал нэмэгдэж оны эцэст -1,235.6 сая төгрөг болсон байна.

УИД ХК нь 2018 онд ААНОАТатварт 44.1 сая төгрөг, НӨАТатварт 297.8 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө болон газрын албан татварт 128.6 сая төгрөг, ХХОАТатвар болон НДШимтгэлд 16.0 сая төгрөг, нийт дүнгээрээ 486.5 сая төгрөгийг Улсын төвлөрсөн төсөвт төлсөн байна.

Дээрх нөхцөл байдлуудыг харгалзан үзээд Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2018 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байгаа.

За одоо хурлын дэгийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооны дүгнэлтийг сонсох ёстой. Та бүхэнд миний өмнө дурдсан тоо, баримтууд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг бичсэн хурлын материалыг тараасан байгаа. Та бүхэн танилцсан байх. Иймд цаг хэмнэх болон мөн асуулт хариултад илүү цаг зарцуулах үүднээс шууд эдгээр асуудлуудтай холбоотой үг хэлэх, санал гаргах үе шат руугаа орох саналтай байна. Гэхдээ зайлшгүй уншиж сонгох шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга уншиж танилцуулж болно. Тэгэхээр үг хэлэх, санал гаргах үе шат руугаа орох уу та бүхэн дэмжиж байна уу?

Хуралд оролцогчид бүгд дэмжиж тавьж өргөн.

С.Сайнбат: Бүгд санал нэгтгэйгээр дэмжлээ. Өнөөдрийн хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Хосбаяр, ердийн гишүүд болон хараат бус гишүүд хүрэлцэн ирсэн байгаа. Тэгэхээр эдгээр хүмүүсээс болон Гүйцэтгэх захирал надаас асуулт асууж, санал хэлж болно. Үг хэлэхдээ тэмдэглэлд тусгуулах боломжийг хангаж нэр, эзэмшиж байгаа хувьцааны тоог хэлэхийг хүсч байна.

Б.Жүгдэррагчаа: Сайн байцгаана уу Би Жүгдэррагчаа байна. 13327 ширхэг хувьцаа эзэмшдэг. УИД бол Монгол улсын Улаанбаатар хотын хамгийн их хүний урсгал хөдөлгөөнтэй, хамгийн их хэрэглэгчтэй барилга байгаа. Мөн Номин Холдинг нь гэдэг томоохон компани гэдэг утгаар нь 2016 онд энэ компанийн хувьцааг авсан. Харамсалтай нь хүндрэл шалтагууд тоочиж байна. Цаашид яах вэ, ашигтай ажиллуулж чадахгүй бол барилгаа зарвал яасан юм бэ. Хэрвээ зарахгүй гэж шийдвэрлэвэл түрээсийн менежментийг хийж байгаа Номин тав Трейд гэдэг компанийг нээлттэй сонгон шалгаруулмаар байна. Мэдээллээ нээлттэй болгоод жишээ нь 30,000-аар түрээслүүлж байгаа бол 40,000, 50,000-аар түрээслээд явах боломжтой компани олдох байхаа. Дараагийн санал бол Номин гэдэг компаниас зээл авсан юм шиг байна. 2013 оноос хойших тайланг нь харахад 11 тэрбум байж байгаад 9 тэрбум болсон байна. Санхүүжилтийн зардал нь зээлийн хүүгийн зардал байна. 1,6 тэрбум байна. Ханшийн алдагдал бас байна. Тэгэхээр доллараар бас зээл байгаа юм байна. Одоо яг хэдэн төгрөгийн болон долларын зээл үлдээд байгаа вэ. Хүү нь хэд вэ? Цаашлаад 2019 ондоо ашигтай ажиллаж чадах уу? Ирэх онд тухайлбал 500 сая төгрөгийн агааржуулалтын засварын зардал гарахаар байна тэгэхээр дахиад алдагдалтай гарахаар байна. Өр зээлээ мөн хувьцаанд шилжүүлж гэж байгаа юм байна энэ нь санхүүжилтийн өртөгөө дийлэхгүй байгаа компанид бол байж болох хувилбар. Нэгж хувьцаа үлдээр тогтоох вэ гэдэг чухал. Бусад Максомол гэдэг компанийг харахад түрээсийн менежмент хийж байгаа компани нь Максадин гэдэг компани байгаа түрээслэгч нь Максомол групп гэдэг компани байгаа. 2-улаа өгөөжөө өгөөд явж байгаа тэрний хажууд Их дэлгүүр гэдэг компани бол хөл хөдөлгөөнөөрөө 2 дахин илүү байгаа. Тэгэхээр энэ асуудлыг эртхэн шийдэх хэрэгтэй байгаа. Энэ байдлаар бол алдагдал нь улам ихсэхээр харагдаж байна. Иймд барилгаа зарах уу, эсвэл нээлттэй сонгон шалгаруулалт зарлах уу гэдэг асуудлыг шийдэх хэрэгтэй байгаа. За баярлалаа.

С.Сайнбат: За баярлалаа. Нэгдүгээр асуудал нь УИД-ийн барилгыг худалдах тухай асуудал байна. Барилгаа худалдана гэдэг бол хувьцаа эзэмшигч та бүхний шийдэх асуудал. Миний санаж байгаагаар 10 хувийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хэдийд ч саналаа ТУЗ-д гаргаад ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргуулж болно. Энэ саналыг хүлээн авсан ТУЗ нь хуульд зааснаар 40 хоногийн дотор хурал хуралдуулах шийдвэрээ гаргана. Ингээд хурлаар энэ асуудлаа шийдвэрлэж болно. Хоёрдугаар асуудал нь зээлийн асуудал байсан. Долларын болон төгрөгийн зээл байгаа. Зээлийн хүүгийн зардал нь 1,6 тэрбум байгаа. Энэ зээлийн хүүгийн зардлаас гаръя гэвэл өрийг хувьцаанд шилжүүлж болно. Тэгэхээр энэ зээлийн хүүгийн зардалд зарцуулж байгаа дүнгээрээ ашиг нэмэгдэж болно. Өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ асуудлыг хэлэлцээд шилжүүлэхгүй гэж шийдвэрлэсэн. Гэхдээ энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дахин хэлэлцүүлж болно. Өнөөдрийн энэ хурлаар шийдвэрлэх боломжгүй. Яагаад гэвэл хурал хуралдахаас өмнө хурлыг зарлахдаа хэлэлцэх асуудлыг тодорхой оруулсан байх ёстой. Гүрээдугаар асуудал нь барилгаа зараад хосон үлдэх гэсэн асуудал байгаа. Эсвэл ХХК болгох асуудал байж болох юм. Тэгвэл өрийг хувьцаагаар сольж байгаагаар адилаар хувьцаагаа хэдэн төгрөгөөр бодох вэ гэдэг асуудал байгаа. Миний санаж байгаагаар Хөрөнгийн биржийн сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханшаар бодоод компанидаа хувьцаагаа худалдаж болно. Одоогийн байдлаар 850 төгрөг байна гэж харж байгаа. 148 ширхэг хувьцаатай хүн бол 80 орчим мянган төгрөгөөр компанидаа зарж болно. Зарахгүй гэвэл хувьцаа эзэмшигч хөвөөрөө үлдэж болно. Тэгэхээр үүнийг ээлжит бус хурлаар шийдвэрлэж болно.

Түрээсийн менежментийг хэрхэн сонгож байгаа вэ гэдэг асуудал байгаа. Энэ асуудал 2016 онд яригдаж нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Өөр иргэн, компани оролцоогүй. Учир нь нийт 25,000 мкв талбай байгаа. Хөндлөнгөөс харахад энэ талбайгаа нэгдүгээр давхрын талбайг 100,000 төгрөгөөр түрээслэдэг юм чинь 100,000-аараа үржүүлээд 2,5 тэрбум төгрөгийн ашиг олох юм байна гэж харагддаг юм шиг байна. Одоо СЗХ-ны шалгалт орж байгаа. Түүнтэй холбоотойгоор Номин Холдинг, Номин Реалтор, Номин Тав Трейд компаниудын тооцоог шалгаж байгаа. Шалгалтын дүн гарахаар тодорхой болох байх. Номин Тав Трейдийн өгсөн мэдээллээр 25,000-аасаа ашиггүй талбайгаа хасаад 22,000 орчим мкв ашигтай талбайг түрээслэж байгаа гэхдээ байнга 100 хувийн дүүргэлтэй байдаггүй, заримдаа түрээслэгч олдохгүй, 80 хувийн дүүргэлттэй байдаг үе ч байдаг. Заримдаа түрээслүүлэх талбай дуусчихсан байдаг, байршилнаасаа хамаараад талбайн үнэ бас харьцангуй, мөн нэг түрээслэгчээс нөгөө түрээслэгчээс шилжихэд эхний хэдэн сар үнэгүй байна гэдэг, эсвэл хийж дуустлаа үнэгүй байна гэх мэтээр харалцан адилгүй. Гэтэл ихэнх хүмүүс бүх талбайгаа метр квадрат тутмыг нь 100,000-аар түрээслэх боломжтой гэж ойлгодог. Хувьцаа эзэмшигч та бүхэн хэрхэн боломжтой бол, хэнийнх болон УИД-ийн 7 билүү 6 давхрын талбайг тэд мөнхөй түрээслэх бэлний үнээс бага үнээр түрээслэж байна. Үүнээс харахад нээлттэй сонгон шалгаруулалтаа ирээдүйд өөр компани орж ирэхгүй, шалгалтаа ирээдүйд тогтоогчийг хийж үзсэний үндсэн

дээр жижиглэнгийн түрээсийн үйл ажиллагаа явуулах нь тийм их ашигтай ажиллаж чадахгүй юм байна гэж үзсэн. 2-рт маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийх юм байна гэдгийг мэдэж байгаа. Түрүү дурдсан түрээслэгч нь 5,4 тэрбум төгрөгийн түрээсийн төлбөр төлдөг, мөн Номин-Таз Трейд бусад зардалдаа 3,5 тэрбум төгрөгийн зардал гаргадаг гэж ойлгосон. Үүнээс харахад энэ их зардлаас давсан хэмжээний ашиг олно гэдэг хүндрэлтэй гэж үзээд сонгон шалгаруулалтад өөр компаниуд орж ирээгүй байгаа. Гэхдээ бид үүнийг мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах шийдвэрлүүлсэний үндсэн дээр дахин зарлаж болох юм.

Б.Жүгдэррагчаа: Зээлийн талаар

С.Сайнбат: Төгрөгийн болон долларын зээлтэй байгаа. Долларынх нь 1,22 хувь байгаа. ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн А.Норсмаа энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.

А.Норсмаа: Сайн байцаана уу. УИД ХК нь өнөөдрийн байдлаар 1,814,000 ам.долларын зээлийн үлдэгдэлтэй, зээлийн хүү нь 1,22 хувь, 4,766,000,000 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн хүү нь 1,59 хувьтай байна.

С.Сайнбат: Энэ талаар нэмэлт мэдээлэл хүргэхэд өнгөрсөн ТУЗ-ийн хурлаар долларын зээлийг төгрөгт шилжүүлэх шийдвэр гарсан. Энэ нь Монгол улсад төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх ёстой гэсэн хуулийн болон Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагаар шилжүүлж байгаа гэж ойлгосон. Гэхдээ зээлдүүлэгч нь өөрөө валютын эх үүсвэртэй тул долларын зээлийг төгрөгийн зээл болгоход хүү нь арай өндөр буюу 1,99 хувь болно гэсэн санал ирүүлсэн байгаа. Бид бас өөр банк, санхүүгийн байгууллагад хүсэлт тавья гэж байгаа. Гэхдээ хүсэлт нь асуудалтай байгаа. Тодруулбал, зээлийг зээлээр хааж болдоггүй юм байна. Тэгэхээр өөр шийдлээр хүсэлтээ гаргаж болох байгаа. Өөр асуулт байна уу.

Ичинхорлоо: Би Баянзүрх дүүргийн 23-р хорооны иргэн Ичинхорлоо байна. Ногдол ашигын талаар асууя. Саяхан 2 сард Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээлэл хийсэн. Тэр мэдэгдэлд УИД 2015 онд 30,000 төгрөгийн ногдол ашиг өгсөн. УИД нь ашигтай ажилладаг боловч Номин Холдинг компанитай хамтран ажиллаж байна. Номин Холдинг нь 3 тэрбум төгрөгийн ашигтай ажилладаг гэж байсан. УИД 45,000 хувьцаа эзэмшигчтэй гэх зэрэг мэдээлэл хийж байна лээ. Эмээ нь 1994 оноос хойш хувьцаа эзэмшигч байгаа, нэг ч удаа ногдол ашиг авч үзээгүй. Жилд нэг удаа дансны хуулга авахаар 7төг50мөнгө гэдэг. Тэгэхээр энэ ногдол ашгаа хаанаас яаж авах вэ?

С.Сайнбат: Та хэдэн ширхэг хувьцаатай вэ?

Ичинхорлоо: 149

С.Сайнбат: Би түрүү дурдсанчлан манай компани бараг 37 сая ширхэг хувьцаатай. 45,000 ширхэг хувьцаа эзэмшигчтэй. Үүн дээр асуудал үүсдэг. 149 ширхэг хувьцаатай хувьцаа эзэмшигч 30,000 төгрөгийн ногдол ашиг сана гэвэл компани 7 тэрбум гаран төгрөгийн ашигтай ажиллах ёстой болно. Түрүү та бүхэнд хэлж байсанчлан 3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан гэж тооцвол нэг хувьцаа эзэмшигчид 12,000 төгрөг оногдоно. Мөн өөр нэг мэдээлэл байна. 2008, 2010 онд гэж санаж байна 2 удаа ногдол ашиг тараасан боловч Төвлөрсөн хадгаламжийн төвд хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа аваагүй 200 сая орчим төгрөг байгаа гэж сонссон.

Ичинхорлоо: Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээлэл хийхдээ 15 онд 30,000 төгрөгийн ногдол ашиг тараасан гэх шиг болсон.

С.Сайнбат: Та буруу мэдээлэл авсан юм шиг байна. Компаниас 30,000 төгрөгийн ногдол ашиг тараагаагүй. Санхүүгийн зохицуулах хороо ч ингэж мэдээлэл хийгээгүй байх гэж бодож байна. Хорооноос 2016 онд шиг санагдаж байна, шалгалт хийгээд 3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж болох байсан юм шиг байна гэсэн дүгнэлт гаргасан гэхдээ энэ нь өрийг хувьцаанд шилжүүлсэний дараахь байдлаар ч юм уу өөр хувилбаруудаар тооцож гаргасан дүн. Тэгэхээр танд хувь хүний зүгээс зээлэхэд хувьцаагаа өнөөдрийн ханшаар худалдах боломжтой. Тэгвэл 80,000 төгрөг орчим болно.

Ичинхорлоо: Хувьцааны үнэ өсөхгүй байгаа. 1000 төгрөг болчихвол болж байна.

С.Сайнбат: Тэр бол таны эрхийн асуудал. Бид хэдэн жилийн өмнө хувьцааны үнээ өсгөх үйл ажиллагааг хуулийн дагуу хийж байсан.

Ичинхорлоо: Ногдол ашиг авахгүй гэж ойлгож болох уу?

С.Сайнбат: Энэ жилийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэр гарсан.

Ичинхорлоо: За ойлголтос. Баррлааа

Б.Жүгдэррагчаа: Компани хуралдааныг хэлээндлэ бодлого байна үү?

С.Сайнбат: Тийм шийдвэр гараагүй. Гэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлаас ХХК болгоё гэж шийдвэр гарвал хувьцаа буцааж худалдан авах дуудлага хийх байх.

Б.Жүгдэррагчаа: Түрээсийн гэрээн дээр ашиглалтын зардлыг түрээслэгчээр хариуцуулах, хуваах өөрчлөлт оруулах боломж байгаа юу?

С.Сайнбат: Би түрүү дурдсанчлан Цахилгааны зардал гэхэд нийтийн эзэмшлийн цахилгааны зардал л байгаа. Түрээслэгч өөрөө ашиглаж байгаа цахилгааны зардлаа бол тусдаа төлөөд явж байгаа. Бусад зардлуудын хувьд түрээслэгчээр хариуцуулна гэхээр зөрүүлээд түрээсийн төлбөрөө буулга л гэх асуудал яригдах байх.

Б.Жүгдэррагчаа: Номин тав трейд компанитай харилцан тохиролцож болохгүй юу?

С.Сайнбат: Номин тав трейд компанитай энэ талаар ярилцаж үзье. Хувьцаа эзэмшигчдийн ийм санал байна гэдэг талаас нь

С.Сайнбат: Компанийн нийт 45,000 хувьцаа эзэмшигчдээс хувьцаа эзэмшигчдийн хуралдаа маш цөөхөн хувьцаа эзэмшигч оролцож байдаг. Мөн үйл ажиллагааны явцад гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-д ирүүлж байгаа санал маш хайгалтгүй байгаа атлаа сошиал дээр мэдээний доор нэр хаяггүй янз бүрийн юм бичдэг асуудал их байгаа. Тэгэхээр хувьцаа эзэмшигчид маань саналаа хурал дээрээ болон үйл ажиллагааны явцад ирүүлж байвал бид аль болох үйл ажиллагаандаа тусгаад явна гэдгээ илэрхийлж байна. Өөр санал хэлэх хүн байна уу.

Хэсэг хүлээв.

С.Сайнбат: Байхгүй бол саналын хуудсаа бөглөж тооллогын комиссын гишүүдэд өгөөд дүн гартал түр завсарлая.

Хурал түр завсарлав.

С.Сайнбат: Тооллогын комиссын дүн гарсныг уншиж танилцуулъя.

"Улсын Их Дэлгүүр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу санал хураалтын дүнг үндэслэн Тогтоох нь:

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар хуралд оролцсон гишүүд дараах байдлаар санал өгснийг баталсугай. Үүнд:

	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	Хувьцааны тоо	Хувь
	Зөвшөөрсөн	22,234,469	99.93
	Татгалзсан	14,204	0.064
	Түдгэлзсэн		

	Компанийн 2018 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг батлах	Хувьцааны тоо	Хувь
	Зөвшөөрсөн	22,234,469	99.93
	Татгалзсан	14,055	0.063
	Түдгэлзсэн	159	0.001

3	Компанийн 2019 оны ТУЗ-ийн зардлын төсвийг батлах	Хувьцааны тоо	Хувь
	Зөвшөөрсөн	22,235,436	99.93
	Татгалзсан	13,227	0.059
	Түдгэлзсэн		

Нийт 42 саналын хуудас тараагдсанаас 36 саналын хуудас хураалгасан байна. Үүнээс хүчинтэй 33, хүчингүй 3 хуудас, санал хураалтын 6 ширхэг саналын хуудас хураалгаагүй, урьдчилж 0 саналын хуудас ирүүлсэн байна.

Тооллогын комиссын:

Дарга..... /
Гишүүд..... /
..... /

Энэхүү тооллогын комиссын тогтоолыг үндэслээд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах тогтоол гарч байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ТОГТООЛ №02

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ, Аудитын хорооны дүгнэлт, ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62, 63 дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

Компанийн 2018 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд гаргасан ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг баталсугай.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг хавсралт №01-ээр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

С.САЙНБАТ

С.Сайнбат: За ингээд УИД ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул хурал хаасныг мэдэгдье. Хуралдаа оролцсон та бүхэнд баярлалаа.

Хурал 12 цаг 10 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

В.Хүрэлхад

Танилцсан:

С.Сайнбат

